## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

2024.10.30 Есөнзүйл сум

| ХБТББ-т тусгагдсан зорилт, үйл ажиллагаа | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2023 | | | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | | | | | | |
| **4.1. Ногоон хөгжил** | | | | | | | | | | | |
| Зорилт 1. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. | 1 | Усны нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх зорилгоор булаг шандны эхийг хамгаалж, хөв цөөрөм байгуулна. | 2021-2022 | БОАХ Мэргэжилтэн | 70,0 сая ОНТ | 336 | 20 булаг шандны эх хашиж хамгаалсан байна. | | | Ундны усны сорьц дээжийн шинжилгээг сумын эмнэлэгийн байгууллагаар ариутгуулж зохих журмын дагуу саванд хийж аймгийн Мэргэжлийн хяналтын лабортoрид шинжилүүлсэн. Хариуг холбогдох газарт хүргүүлсэн. Мөн Мөнхбулагийн 2 дугаар багийн нутагт дэвсгэрт орших булгийн эхийг Өвөрхангай аймгийн байгаль орчны газраас сумдад хуваарилсан 40 ширхэг сургаагаар хашин хамгаалж Хайрханы 3 дугаар багийн иргэн С.Пүрэвтэй гэрээ хийн хүлээлгэн өгч хариуцан хяналт тавин ажиллахыг үүрэг болголоо. | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт2. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2 | Хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэн аж ахуй нэгж, байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулж, эх үүсвэр дээр нь ангилж, хөдөө нутаг, гол усны хогийг цэвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2020-2024 | БОАХ Мэргэжилтэн | 186,0<br><br>Улс, орон нутгийн төсөв<br><br>Төсөл хөтөлбөр | Анг | 800 тн | | | Сумын Мөнхбулаг 2 дугаар багийн иргэдэд цооног болон эко 00-той болох уриалга гарган одоогоор сумын төвийн 60 өрх уриалгад нэгдэн бохир усны цооног болон эко 00-той болоод байна. Сумын хөдөөний Тахилга, Хайрхан, Эрээн багуудын Иргэдийн нийтийн хуралд зөөврийн 00 түүний ач холбогдолыг танилцуулан хийж хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээллийг хүргэлээ. Сумын өвөлжөө хаваржаа эзэмшдэг нийт 700 гаруй өрхийн 250 өрх буюу 45% нь зөөврийн болон био 00 хийгээд байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны Тэргүүлэгчдийн тогтоолын дагуу улирал бүр “Бүх нийтийн цэвэрлэгээ”-ний ажлыг хавар, намар гэсэн үе шаттайгаар нийт 2 удаа Засаг Даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Сургуулийн Өмнөх Боловсролын Байгууллагуудыг хамруулан зохион байгуулж 300 гаруй хүн хүн, 20 гаруй авто машиныг хамруулан нийт 54 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан. Мөн сумын төвийн айл өрхүүдэд өөрийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэхийг уриалан хамтран ажиллалаа. Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн, 4 багийн Засаг дарга нартай хамтран хүнсний эрхийн бичиг авдаг 18 иргэнийг 2 өдөр 3 хэсэг болгон хувааж, сумын төвийн баруун, зүүн голын голдрилууд, сумын төвийн нутаг болох Арлын ухаагаас Бумбатын хөтөл ортол улсын чанартай авто зам дагуух сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж нийт 5 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан. 5 дугаар сарын эхний арав хоногоос бүх нийтийн мод тарих өдрүүд эхэлж байгаатай холбоотойгоор “Өндөр Гэгээн Занабазарын Номын Өргөө” цэцэрлэгт хүрэлэнд тарисан | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | улиас, бургас, шинэс модонд тандалт, тайралт хийж, орчны хог хаягдлыг цэвэрлэж, цэнэг усалгаа хийсэн. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын мод тарих өдрүүдээр сумын хэмжээнд “Бат цэцэрлэгжилт” ХХК-тай хамтран мод үржүүлгийн газар, албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдтэй хамтран бургас, улиас, хайлас зэрэг 20200 гаруй мод тарисан. Мөн мод усалгааны ажлыг ТҮК-ийн Э.Батсүх нь 14 хоногт 2-3 удаа хийсэн. | |
| | 4 | Гэр хороолол, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдэд дэвшилтэт технологи бүхий “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | 2020-2024 | БОАХ Мэргэжилтэн | Улс, орон нутгийн төсөв<br><br>Төсөл хөтөлбөр | Эко | 300 ширхэг суурилуулсан | | | Гэр хорооллын 2 худгийн усыг шинжилгээнд хамруулсан. 2 худагт хамгаалалтын бүс тогтоосон. Сумын төвийн айл өрхөөс 5 айл эко жорлон барьж хөрсний бохирдлыг бууруулахад хувь намрээ оруулллаа. | 70 |
| | 5 | Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг өргөжүүлж, | 2020-2024 | БОАХ Мэргэжилтэн | 40,0<br><br>Улс, орон нутгийн төсөв | | 19 сумын ашиглалтад өртөмтгий ургамлын тархац нөөцийн судалгааг | | | Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг өргөжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулж, судалгааг жил бүр гарган ажиллаж байна. Мөн эмийн болон ховор ургамлын судалгааг гарган ажиллаж байна.Ан амьтны хамгаалалтыг сайжруулах зорилгоор эргүүл, | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамгаалалтын менежментийг сайжруулна. | | | Төсөл хөтөлбөр | | мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байна. | | | хяналт шалгалтыг тогтмол хийн ажиллаж байна. Жил бүр зэрлэг ан амьтан болох аргаль, хонь, буга согоонд амьдрах орчныг сайжруулах зорилгоор өвс, хужирыг 8-10 удаа мэргэжлийн улсуудтай хамтран тавьж өгсөн. Иргэний дуудлагын дагуу Байгаль Орчны Хяналтын Улсын Байцаагч Д.Мөнхбаяр, Байгаль хамгаалагч Л.Анхбаяр, Цагдаагийн хэсгийн төлөөлөгч Т.Амарсанаа, ЗДТГ-ын жолооч Н.Балжинням нарын хамт Баян-Үйлст Хайрхан, Ташуу, Улаан чулууны хөтөл, Хүрэн-Өндөр, Дөлгөөн, Гацааны эх зэрэг газруудаар явж хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтын үеэр гарсан зөрчил илрээгүй.Мөн БОАЖЯ-ны Сайдын 2023 оны 03-р сарын 17-ны өдрийн А/70 дугаартай “Халиун бугын эврийг түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай” тушаалын дагуу халиун бугын эвэр түүж бэлтгэх, худалдаалах, тээвэрлэх хөөж элдэх эрсдлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй бөгөөд амьтны тухай хууль, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бугын эвэр түүх зорилгоор ан амьтныг үргээхгүй байх талаар иргэдэд мэдээлэл хүргэж ажиллалаа. Сумын 2024 оны хэрэгжүүлэх байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын амьтдын амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд 2-р багийн С.Эрдэнэхуяг, Ш.Даваасүрэн нартай гэрээ бйагуулан, ажлын гэрч нийт 22 ширхэг шувууны суултуурийг өндөр хүчдэлтэй газар үүрээ зассан, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан сүйтсэн Тарвагатай, Мэлзэн, Галуут, Өвөр худаг, Буянаа, Майнт, Цац гэх газруудад байрлуулж, зарим хуучин үүрийг нь засварлан байршуулсан. Агнуур судлалын нийгэмлэг төрийн бус байгууллага нь тарвага нутагшуулахаар 25 ширхэг тарвагыг | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | “ Улаан чулуут ” гэдэг газарт нутагшуулсан. Одоогийн байдлаар нутагшуулсан тарваганууд тогтвортой тайван байдалтай, 14-15 мөндөлтэй байна. | |
| | 7 | Төрийн үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2020-2024 | БОАХ Мэргэ Жилтэ Н | 40,0 сая ОНТ | | Байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн<br><br>боловсрол ыг олон нийтэд сурталчла н, стандарт хэм хэмжээг нэмэгдүүл | | | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/76 дугаар тушаалуудын хүрээнд хавар иргэд бугын унасан эвэр түүх зөрчил их гадаг учир суманд ажлын төлөвлөгөө боловсруулж нутгийн 400-аад айл өрх давхардсан тоогоор 550 иргэдэд хууль бус бугийн эвэр түүх , ой хээрийн түймрын урьдчилан сэргийлэх 350 гаруй брошур гарын авлага бэлтгэн тараан иргэдэд байгаль хамгаалах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэдээ мэдээлэл өгөн ажилласан. Иргэдийн байгаль орчныг хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор багийн иргэдийн нийтийн хуралд орчны бохирдол, ан амьтныг хайрлан хамгаалах талаар мэдээлэл хийж байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. | 100 |
| Зорилт 3. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хомсдол, доройтлыг зогсоох, нөхөн сэргээх, ойжуулах замаар | 1 | Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагуу дыг бодлогоор дэмжиж, ойжуулалт, төв суурингийн ногоон байгууламжид | 2021-2024 | БОАХ Мэргэ жилтэ н | 290,0<br><br>Улс, орон нутгий н төсөв<br><br>Төсөл хөтөлб өр | Тарьц суулга ц 162, | Ургуулах тарьц, суулгацын тоо 80 мянган ширхэг байна. | | | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан сумын газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд 2-3га газрыг мод тарихаар тусгуулан ажиллалаа. Төлөвлөгөөнд тусгагдсан талбайг 20 сая төгрөгөөр хашаажуулан улиас, хайлаас, бургас зэрэг нийт 1000 модыг суулган тариад байна. Хөгжил нэгдлийн ууган гишүүн Ж.Гүнд болон анхны 17 гишүүдийн нэрэмжит Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг бий | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн менежментийг бүрдүүлнэ. | | шаардлагатай тарьц, суулгацаар аймгийн хэрэгцээг бүрэн ханган, ойжуулах ажлыг төсөл хөтөлбөрт хамруулах санаачлага гарган ажиллана. | | | | | | | | болгон улиас, хайлаас, бургас, агч зэрэг нийт 1500 модыг суулган тарьлаа. “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг 3 компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан 2023 онд ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах бэлтгэл ажил хангагдаад байна.Мод услахад зориулан портер машин усалгааны сав, усны помп зэргийг аван зорилтод жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Сумын иргэдийн ахуйн хэрэгцээнд зориулан рашааныг автомат төхөөрөмж суурилуулан иргэд хэрэгцээгээ хангаж байна. Сумын хэмжээнд хоёрдогч түүхий эдэд ангилан ялгалт хийх, арчилгаа хамгаалалтыг хариуцан ажиллах тохижилт үйлчилгээний ажилтаныг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3 хүний бүрэлдэхүүнтэй тохижилт үйлчилгээ хариуцсан Бүлэг байгуулан гэрээгээр ажиллуулж байна. Тохижилт үйлчилгээний 1 ажилтаныг 500,000 төгрөгөөр цалинжуулж байна. Ногоон зээлийн санд хэрхэн хамрагдах талаар зээлд хамрагдсанаар гарах үр ашгийн талаар иргэдэд сурталчлан төрийн болон хаан банкаар дамжуулан хэрэгжих ногоон зээлийн санд хамрагдах аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн саналыг үндэслэн судалгаа гаргаж хамтран ажиллаад байна. Зорилтод жил болон “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд Сумын Засаг даргын Захирамжаар “Бат цэцэрлэгжилт” ХХК-д 15 га газрыг мод үржүүлгийн зориулалтаар олгож мод үржүүлгийн газар байгуулаад байна. Мод үржүүлгийн газар байгуулах ажлыг 06 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авсан бөгөөд тухайн тендерийн үйл ажиллагааны улмаар нийт 20000 гаруй мод | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | тарин хашаажуулан усалгааны системийг бүрэн хийж гүйцэтгүүлээд байна. Сумын хэмжээнд мод үржүүлэлтийн газар байгуулж 15 га газар 10000 мод тариад байна. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын мод тарих өдрүүдээр сумын хэмжээнд “Бат цэцэрлэгжилт” ХХК-тай хамтран мод үржүүлгийн газар, албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдтэй хамтран бургас, улиас, хайлас зэрэг 20200 гаруй мод тарисан. Мөн модны цэнэг усалгааны ажлыг Байгаль хамгаалагч Л.Анхбаяр, ТҮК-ийн Э.Батсүх нь 14 хоногт 2-3 удаа тогтмол хийж гүйцэтгэсэн. | |
| **4.2.Аялал жуулчлал** | | | | | | | | | | | |
| Зорилт 1. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 11 | Сум бүрт байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ бий болгож, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүн бий болгоно. | 2022-2024 | БОАХ Мэргэжилтэн | Улс, орон нутгийн төсөв<br><br>Төсөл хөтөлбөр | Аялал жуулчлалын маршрутад | 12 см | | | Сумын аялал жуулчлалын маршрутыг төв замаас Номын өргөө, Сумын төв, Хүн чулуу, Зүүнхайрхан, Сэрүүн булаг, Хэрэмний үүд, Буурлын хөшөө, Цагаан толгой, Суврага, Наран толгой, Сангийн далай гэх зэрэг 11 цэгийг дайран 148-200 км-ээр тогтоож, маршрутын дагуух малчин иргэдийн үйлчилгээг холбох, гэр кэмп, гайст хаус, ажиллуулах иргэдийн судалгааг авч ажиллаж байна. Сурагчдын зун амралыг ая тухтай, байгаль, түүх, соёл, монгол аж ахуйтай ойр байлгах зорилгоор Хөдөлмөр зуслан байгуулахаар барилгын ажил эхлээд явж байна. | 90 |
| | 12 | Аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, | 2023-2024 | БОАХ Мэргэжилтэн | Улс, орон нутгийн төсөв<br><br>Төсөл хөтөлбөр | 2018-2022 онд хэрэгжих | - | | | 2021 онд сумын 1, 3 дугаар багийн нутаг Дэлгөөн хайрхан, Өвтийн сархиа, Зүүнхайрханы сав газруудад амьдардаг 10 өрхийн 32 иргэнд сумын, аймгийн, улсын аялал жуулчлалын олон талт ач холбогдол, үр ашиг, өөрсдийн нөөц боломжийг дайчилж, ирсэн гадаад дотоодын жуулчдад | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлж, ажиллана. | | | | дэд хөт өлб өр | | | | нутаг орон, байгалийн үзэсгэлэнт газрууд, ховор болон нэн ховор ан амьтад, ёс заншил, өөрсдийн хийж бүтээсэн бүтээл, бүтээгдэхүүнийг зөв сурталчилах, үйлчлэх, үйлчилгээгээ харилцан тохиролцож үнэлэх гэх мэт олон асуудлаар мэдээлэл өгч хамтран ажиллах санал тавьсан. Мөн амарч аялж яваа гадаад дотоодын иргэдтэй зөв боловсон харьцах, тав тухыг алдагдуулахгүй байх, иргэдээс шалтгаалах хүчин зүйлсийг тайлбарлан таниулж өгсөн. Аялал жуулчлалын салбар нутгийн малчин иргэдийн оролцоо чухал бөгөөд тэдний малын гаралтай цагаан идээ, уламжлал ёс заншил, соёл урлаг, эд хэрэглэл, адуу малын аливаа үзүүлбэр, төлбөрт үйлчилгээ гэх мэт олон бүтээгдэхүүн үйлчилгээгээр ашиг орлого олох боломжийг дээрх 10 өрхийн 32 иргэнд таниулан сурталчилсан. Сумын аялал жуулчлалын маршрутыг төв замаас Номын өргөө, Сумын төв, Хүн чулуу, Зүүнхайрхан, Сэрүүн булаг, Хэрэмний үүд, Буурлын хөшөө, Цагаан толгой, Суварга, Наран толгой, Сангийн далай гэх мэт 11 цэгийг дайран 148-200 км-ээр тогтоож, маршрутын дагуух малчин иргэдийн үйлчилгээг холбох, гэр кемп, гайстхаус, ажиллуулах иргэдийн судалгааг авч ажиллаж байна. Сумын цахим хаягаар сумын аялал жуулчлалын талаарх мэдээллийг түгээн ажиллаж байна. Тусгай хамгаалалттай газар болон аялал жуулчлалын замын чиглэлийн таних тэмдэг, анхааруулах самбарыг шинэчлэн байршууллаа. Дөлгөөн хайрханы Сэрүүн булгийн Гацааны аманд аялал жуулчлалын зориулалтаар 3 шовоохой барьж, тогтмол ажиллуулж амрагчдын тав тухыг ханган ажиллаж байна. | |

| | |
|---|---|
| **Дундаж үнэлгээ** | **92,5%** |
| **Ерөнхий үнэлгээ** | **92,5%** |

ХЯНАСАН:ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ